



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/38

Мандалговь

Г Эзэмшил газрын хэмжээг өөрчилж, Г
нэгж талбарыг нэгтгэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дахь заалт, 31 дугаар зүйлийн 31.2 дахь заалт, эзэмшил газраа нэгтгэж гэрчилгээ авах иргэний хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Худалдааны гудамж-2-208)-т байршилтай иргэн Чулуунбатын Мөнхдалай (ЗЮ:87031870)-ийн үйлчилгээний зориулалттай 40м.кв (0.004га), гаражийн зориулалттай 36м.кв (0.0036га), гаражийн зориулалттай 24м.кв(0.0024га) эзэмшил газруудыг нэгтгэж одоо байгаа 111м.кв(0,01га) болгон хэмжээг өөрчилж зориулалтаар нь 14 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/359 дүгээр захирамж, аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/302 дүгээр захирамж, аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/528 дугаар захирамжийн холбогдох хэсэг мөн газар эзэмших 000712036, 000692906 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010057